



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 22

Мөрөн

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. 2020 онд тэгш ой нь тохиож байгаа боловсролын байгууллагуудын ойг хавсралтад дурьдсан хугацаанд тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Ойг тэмдэглэх арга хэмжээний бэлтгэл зохион байгуулалтыг бүрэн хангаж, журмын дагуу тэмдэглэн өнгөрүүлэхийг холбогдох сумдын Засаг дарга, байгууллагын дарга нарт даалгасугай.

3. Ойн хүрээнд зохион байгуулагдах үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллахыг аймгийн Боловсрол, соёлын газрын дарга (Ц.Ганзориг)-д даалгасугай.


4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар  
сарын 20 өдрийн 23 тогтоолын хавсралт



2020 онд ойгоо тэмдэглэх байгууллагууд

№	Байгууллагын нэр	Ой	Тэмдэглэх хугацаа
1	Галт сумын ерөнхий боловсролын сургууль	80 жил	2020.07.29-30
2	Галт сумын Зүрх багийн цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор	80 жил	2020.07.27-28
3	Төмөрбулаг сумын ерөнхий боловсролын	80 жил	2020.07. 16-17
4	Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургууль	80 жил	2020.07.16-18
5	Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургууль	80 жил	2020.07.16-18
6	Чандмань-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль	80 жил	2020.07.14-15
7	Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль	80 жил	2020.07.16-18
8	Их-Уул сумын ерөнхий боловсролын сургууль	80 жил	2020.07.16-17
9	Их-Уул сумын хүүхдийн цэцэрлэг	60 жил	2020.09.19-20
10	Ерөнхий боловсролын "Титэм" сургууль	50 жил	2020.10.03-04
11	Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургууль	80 жил	2020.07.14-16
12	Цагаан-үүр сумын хүүхдийн цэцэрлэг	60 жил	2020.09.22-25
13	Ханх сумын ерөнхий боловсролын сургууль	80 жил	2020.07.13-16